

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/27.

Арвайхээр сум

Тарваган тахлын эсрэг вакцинаар дархлаажуулах
ажлыг зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Тарваган тахал өвчний хяналт, сэргийлэлтийн арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр Албан даалгаврыг үндэслэн ТУШААХ нь:

1.Тарваган тахлын байгалын голомтот сумдын эрсдэлт бүлгийн хүн амд Тарваган тахал өвчний эсрэг вакцинаар 2024 оны 06 дугаар сарын 21-нээс эхлэн 07 дугаар сарын 05-ны дотор тархвар судлалын заалтаар дархлаажуулахыг Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Зүүнбаян-Улаан, Тарагт сумд, Нарны дөш, Уянсэтгэл, Түшигдөлгөөн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2.Тарваган тахлын эсрэг вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Тарваган тахлын эсрэг вакцины ач холбогдолын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, эрсдэлт бүлгийн иргэдэд зааврын дагуу вакцинжуулах арга хэмжээг зохион байгуулж, маягтын дагуу тайлагнах, мэргэжлийн удирдлаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Зооноз өвчин судлалын төв (Б.Сүхбаатар), сонгогдсон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИВААННҮРДЭВ

622301086 My Doc.tushaa/EMG/

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 06 дугаар сарын 17-өдрийн
А/27 дүгээр тушаалын хавсралт

ТАРВАГАН ТАХЛЫН ЭСРЭГ ВАКЦИН, ДАГАЛДАХ
ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

№	Нэгжийн нэр	Хамрагдвал зохих хүний тоо	Шаардлагатай вакцин /хүн тунгаар/	Тариур 1 мл
1	Нарийнтээл сумын ЭМТ	750	1092	750
2	Хайрхандулаан сумын ЭМТ	400	624	400
3	Уянга сумын ЭМТ	950	1404	950
4	Зүүнбаян-Улаан сумын ЭМТ	350	468	350
5	Тарагт сумын ЭМТ	350	468	350
6	Нарны дөш ӨЭМТ	400	624	400
7	Түшиг Дөлгөөн ӨЭМТ	400	624	400
8	Уянсэтгэл ӨЭМТ	400	624	400
Нийт		4000	5928	4000

оОо